



ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ
САЛБАРЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ДААЛГАВАР

2025 - 05 - 11

Дугаар 02-00/02

Улаанбаатар хот

Өргөх байгууламжийн техникийн
ажуулгүй байдлыг хангуулах тухай

Монгол Улсад өргөх байгууламжийн угсралт, ашиглалт, техникийн ажуулгүй байдал бүрэн хангагдаагүй байдлаас 2025 онд Хан-Уул дүүрэгт цамхагт краны угсралтын ажил хийж байгаад 1 хүн унаж нас барсан, Сүхбаатар, Баянзүрх дүүрэгт цамхагт кран эргэж барилга мөргөсөн, Чингэлтэй дүүрэгт дүүжин өргүүр унаж 1 хүн нас барж, 1 хүн хүнд гэмтсэн, Ховд аймагт ачааны өргүүр унаж 3 хүн нас барж, 3 хүн хүнд гэмтсэн, 5 хүн хүндэвтэр гэмтсэн байна.

Иймд Барилгын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.5 дахь заалт, дүрэм болон холбогдох стандартын хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, өргөх байгууламжийн техникийн бүрэн бүтэн байдал, ажуулгүй ажиллагааг хангаж эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажиглалзыг өргөх байгууламжийн угсралт, засвар, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага болон эзэмшигч, ашиглагч байгууллага, иргэдэд ДААЛГАХ нь:

1. Өргөх байгууламжийн техникийн бүрэн бүтэн байдал, ажуулгүй ажиллагааг хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллах. Үүнд:

1.1. Өргөх байгууламж эзэмшигч, ашиглагч нь түүний ажиллагаанд хяналт тавьж, засвар, техник үйлчилгээг тогтмол хийж, техникийн бүрэн бүтэн байдал, ажуулгүй ажиллагааг хангах;

1.2. Өргөх байгууламжийн засвар, техник үйлчилгээг эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах;

1.3. Өргөх байгууламж эзэмшигч, ашиглагч нь техникийн ээлжит магадлалыг 12 сар тутамд нэгээс доошгүй удаа хийлгэж техникийн байдлыг тодорхойлж илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах;

1.4. Өргөх байгууламжийн ажуулгүй ажиллагаа хариуцагч, мэргэжлийн үнэмлэхтэй операторчигч тушаалаар томилж ажиллуулах;

1.5. Аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн ажуулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өечнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах;

1525110012

2. Ачааны SMZ, SSE загварын өргүүр ашиглахыг хориглох.
3. Дүүжинт өргүүрт зориулалтын эсрэг ачаа тавих, баригчийн төхөөрөмжөөр тоноглогсон байх.
4. Лифтийн хонгилын хаалгыг зориулалтын хаалтаар хаших.
5. Энэхүү албан даалгаврыг хэрэгжүүлж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг өргөх байгууламжийн угсралт, засвар үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллага, эзэмшигч, ашиглагч байгууллага, иргэдэд үүрэг болгосугай.
6. Албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг барилга, өргөх байгууламжийн техникийн хяналтын улсын (ахлах) байцаагч нарт үүрэг болгосугай.

САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ



Б.САНЧИРДОРЖ